



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Хангарди ордон, Нийслэлийн засаг захиргааны II байр,  
Ц.Жигжиджавын гудамж-9, Бага тойруу-3,  
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-11) 32-50-76  
E-mail: ubhd@emg.ub.gov.mn, http://www.ubhealth.mn

2020.02.20 № 1/149

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ДАРГА НАРТ

Үүрэг даалгавар өгөх тухай

Нийслэлийн удирдлагууд коронавирусийн халдвараас сэргийлэх, тэмцэх чиглэлээр дүүргүүдийн бэлэн байдал, холбогдох тушаал шийдвэрүүдийн хэрэгжилт, Авто тээврийн шалган нэвтрүүлэх байнгын ажиллагаатай товчоодын ажил байдалтай танилцаж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын хариуцлага, сонор сэрэмжийг дээшлүүлэн ажиллахыг анхааруулж, тодорхой чиглэлүүдээр үүрэг өгсөн.

Мөн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны өгсөн үүрэг чиглэлийн дагуу НЗДТГ-ын даргаас 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 03/861 тоот албан бичгээр шалган нэвтрүүлэх товчоо, хяналт-шалгалтын цэгт үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдыг албан үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг тус тус үүрэг болгоод байна.

Иймд доорх зөвлөмжийг өгч, холбогдох арга хэмжээг авч, хэрэгжүүлэн тайлагнан ажиллахыг үүрэг болгож байна. Үүнд:

1. Өлзийт товчооны байрыг сайжруулах ажлыг зохион байгуулах.
2. Товчоодын ялангуяа Баруун туруун товчооны байрны /СХЭМТ/ тохижилт, ариун цэвэр, эрүүл ахуйн асуудалд анхаарч, зохих арга хэмжээг авах.
3. Бүх товчоон дээр ажиллах хүний нөөцийг нэмэгдүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, шийдвэрлэх.
4. Товчоо бүрт зайнаас халуун хэмжигчийн тоог нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах.
5. Товчоон дээр ажиллаж буй бүх албан хаагчдыг амны хаалтаар /N95/ хангах, нэгдсэн унаагаар тээвэрлэх, хоолны асуудалд анхаарах, дархлаажуулалтыг нэмэгдүүлэх /аарц, чацарганаар хангах/, витаминжуулах арга хэмжээг авах.
6. Товчоогоор нэвтрэн өнгөрч буй тээврийн хэрэгсэл бүрийг хяналт тандалтанд хамруулах, иргэн бүрийг үзэж, шинэ коронавирусын халдвараас сэргийлэх, амны хаалтаа зүүх, олон нийтийн газраар явахгүй байх зэрэг урьдчилан сэргийлэх мэдээлэл зөвлөмжөөр хангах.
7. Эмнэлгийн бэлэн байдлыг ханган, эрүүл мэндийн үзлэг, тусламж үйлчилгээ болон халдвар хамгаалал, халдваргүйтгэлийн асуудлыг бүхий л шатанд сайжруулан ажиллах.
8. Зөвлөгөө өгөх утасны зөвлөгөө өгч байгаа болон ажиллаж буй байдалд хяналт тавьж, коронавирусийн халдвараас сэргийлэх талаар зөвлөгөө өгөх нэгдсэн арга аргачлалаар ханган, утсыг тогтмол ажиллуулах.

Зөвлөмжийг хэрэгжүүлэн тайланг 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 14 хоног тутамд Эмнэлгийн тусламжийн хэлтэст албан бичгээр ирүүлэхийг анхааруулж байна.

Хувийг НЗДТГ-ын даргын үүргийг түр ордон гүйцэтгэгч Р.Батрагчаад

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

1150500068